



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа "Сүүж-уул" амралт, сэргээн засах сувиллын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон, 2 нэрийн 5,500,000.02 (таван сая таван зуун мянган төгрөг хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын харьяа "Сүүж-уул" амралт, сэргээн засах сувиллын дарга Р.Төмөрбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003004

2022.09.29 22-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн  
188-дугаар тогтоолын хавсралт



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА "СҮҮЖ-УУЛ" АМРАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ СУВИЛАЛЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ  
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д      | Автомашини нэр, марк, улсын дугаар,<br>арал, хөдөлгүүрийн дугаар | Ашиглалтад<br>орсон,<br>бүртгэсэн он | Нийт гүйлт<br>(км) | Балансын нийт үнэ,<br>хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)               | Худалдах доод<br>үнэ (төгрөг)                      |
|----------|--|--------------------------------------|--------------------|---|--|
| 1        | Тоёота ландкрузер-80, 81-82 УБЦ<br>(арал-fzj800035232)           | 2001/2018                            | 390265             | 5,000,000.00  | 4,000,000.00                                       |
| 2        | Фургон, 08-45 УНБ (арал-403602)                                  | 2010/2020                            | 174853             | 500,000.02  | 2,500,000.00                                       |
| Нийт дүн |  |                                      |                    | 5,500,000.02<br>(таван сая таван зуун<br>мянган төгрөг хоёр<br>мөнгө) | 6,500,000.00<br>(зургаан сая таван<br>зуун мянган) |